



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, "Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм"-ийн 2.5.1, 2.5.7, "Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын 3.1.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтээс 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн зохион байгуулж буй Хөрөнгийн үнэлгээчнийг бэлтгэх анхан шатны 14 хоногийн сургалтад Захиргаа, санхүүгийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Б.Батбаяр, Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн Б.Мөнгөнхүү нарыг суралцуулсугай.

2. Сургалтын зардлын 1,000,000 (нэг сая) төгрөгийг зохих сангаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Н.Уранчимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Н.Мөнхбаатар)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

Тушаал-2021

115050000259